



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 30 өдөр

Дугаар A/90

Жаргалтхаан сум

**Бруцеллөз өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалтууд, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2025 оны А/115 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/435 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээний бүх тугал, хурга, ишгийг зааврын дагуу вакцинжуулалтанд хамруулах ажлыг 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2.Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг тогтоосон хугацаанд шуурхай, чанартай хийж гүйцэтгэхийг гэрээт мал эмнэлгийн нэгжүүдийн захирал, малын эмч нарт үүрэг болгосугай.

3.Бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг малчид, мал бүхий иргэдэд зарлан мэдээлж, зохих бэлтгэлийг хангуулан хамтран зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, товлосон хугацаанд тарилгад хамрагдах малаа бэлэн байлгаж бүрэн хамруулах, тарилга хийх хашаа хороо бэлтгэн аюулгүй байдлыг ханган ажиллахыг малчид, мал бүхий иргэдэд даалгасугай.

4.Тарилгын ажилд хяналт тавих, холбогдох мэдээ тайланг цаг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч П.Батдуламд үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэрт үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГАНБАТ

